

ЭРХИЙН ТУХАЙ ГЕРМАНЫ ФИЛОСОФИЧ Г.В.ГЕГЕЛИЙН ҮЗЭЛ САНАА

Х.Сэлэнгэ - МУИС-ийн ХЗС-ийн багш, доктор

Түлхүүр үг: эрх, чөлөөт хүсэл зориг, эрх чөлөө, эрх зүй, хууль, позитив эрх

Товч утга: Эрхийн тухай Германы сонгодог философич Г.В.Гегелийн ойлголт, түүнд хандах онол-арга зүйн асуудал нь өнөөгийн хууль зүйн шинжлэх ухаанд тодорхой байр суурь эзэлсээр байна. Иймд орчин үеийн эрх зүйн сэтгэлгээний онол – арга зүйн үндэс болсон эрхийн тухай Гегелийн ойлголт, онол – арга зүйн асуудлыг И. Кантын эрхийн философитой харьцуулан гаргаж тавьлаа.

Г.В.Гегель нь хүн төрөлхтний философи сэтгэлгээний агуу их сэтгэгч билээ. Гегелийн үзэл санаа нь эрх зүйн сэтгэлгээний хөгжилд онол – арга зүйн их хувь нэмэр оруулсан юм. Эрхийг судлах арга зүйн асуудлыг авч үзвэл: И. Кант нь хүний зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээний /категорический императив/ үүднээс эрхийг байх ёстой зүйлийн хүрээнд авч үздэг бол харин Гегель эрхийг байгаа зүйлийн хүрээнд авч үздэгээрээ ялгаатай. “Ийм байх ёстой”, “тийм байх ёстой” гэдэг бол хоосон утопи санаа, бодит зүйл биш учир байгаа бодит эрхийг судлан, түүний мөн чанарт хүрэхийг эрмэлзэх ёстой хэмээн шүүмжилж байв. Нөгөө талаар шинжлэх ухааны зорилго нь ертөнцийг өөрчлөх бус, харин байгаа бодит зүйлийг танин мэдэж, түүнд хүрэх явдал гэж үзсэн. Өөрөөр хэлбэл, шинжлэх ухаан нь танин мэдэхүйн зорилготой байна.

Байгалийн хууль бол хүний хүсэл зоригоос хамааралгүй абсолют хууль байдаг тул хүмүүс байгалийн хуулинд зайлшгүйн үүднээс захирагддаг. Харин позитив хууль нь абсолют хууль биш. Хүмүүс позитив хуулинд зайлшгүйн үүднээс захирагддаггүй тул хүн бүр эрх зүйн актыг өөр, өөрийн эрхийн ойлголттой нийцүүлэх шаардлага тавьдаг байна. Иймд эрхэд байгаа болон байх ёстой зүйлийн хүрээнд зөрчил байна хэмээн Гегель үзэж, хамгийн “зохистой”, “зөв” эрхийг илрүүлэхийг эрмэлзжээ.

Гегель “зохистой”, “зөв” эрхийг танин мэдэхийн тулд юуны өмнө эрхийн “зохистой”, “зөв санаа”-г танин мэдэх ёстой хэмээн үзэж, эрхийн санааны тухай асуудлыг авч үзсэн. Үнэн санаа гэдэг нь тухайн юмсын ойлголт. Зөв сэтгэхүй бол зөв танин мэдэхүй, зөв мэдлэг. Иймд танин мэдэхүй шинжлэх ухааны байх ёстой хэмээн үзсэн юм. Дээрхи арга зүйн үүднээс Гегелийн эрхийн философи нь чөлөөт хүсэл зоригийг танин мэдэхээс эхэлдэг. Өөрөөр хэлбэл, эрхийн үндсийг материаллаг харилцаа бус, оюун санааны үндэстэй хэмээн үзсэн байна.

Чөлөөт хүсэл зориг нь И. Кантынхаар хүний ухамсарын факт, практик оюун санааны нотлогдохгүй үнэн байдаг аж. Өөрөөр хэлбэл, И. Кантынхаар чөлөөт хүсэл зориг оршин буйг нотлох буюу няцаах боломжгүй юм. Иймд чөлөөт хүсэл зориг оршин буйд итгэх нь чухал байна. Харин Гегель чөлөөт хүсэл зоригийг эрхийн санааг хэрэгжүүлэх зайлшгүй арга хэрэгсэл⁴⁴ гэж үзсэн. Чөлөөт хүсэл зориг нь Гегелийн хувьд оюун санааны нотлогдохгүй үнэн, түүнд итгэх зүйл биш, харин туйлын оюун санааны хөгжлийн хамгийн чухал хэсэг нь юм.

Гегелийн философи дахь чөлөөт хүсэл зоригийн ойлголт нь сэтгэхүй, хүсэл зоригийн өвөрмөц ойлголттой шууд холбоотой. И. Кант сэтгэхүй, хүсэл зоригийг ялгаж, онолын болон практик оюун ухаан, танин мэдэхүй ба хүний үйл ажиллагааны хооронд ялгаатай хэмээн үзсэн. Харин Гегель сэтгэхүй, хүсэл зоригийг нэгдмэлээр авч үзсэнээрээ И. Кантаас ялгаатай юм. Гегель үзэхдээ: “Хүсэл зориг бол сэтгэхүйн хамгийн ойрын үнэн”. “Хүсэл зориг - бодит ахуйд өөрийгөө хувиргасан сэтгэхүй”. “Сэтгэхүйгүй хүсэл зориг гэж үгүй” гэжээ. Иймд

⁴⁴ А.А.Пионтковский. Учение Гегеля о праве и государстве. М. 1993. стр-93

хүнийг нэг талаас хүсэл зоригтой, нөгөө талаас сэтгэх чадвартай хэмээн үзэж болохгүй. Сэтгэхүй, хүсэл зоригийн ялгаа нь гагцхүү онол, практикийн хоорондын ялгаа юм. Учир нь хүсэл зориг бол сэтгэхүйн онцгой арга гэж үзжээ.⁴⁵

Гегелийн философид сэтгэхүй, хүсэл зоригийн нэгдлээс чөлөөт хүсэл зоригийн ойлголт урган гардаг байна. Эрх чөлөө бол хүсэл зоригийн үндсэн шинж, түүний мөн чанар. Хүсэл зоригийг эрх чөлөөнөөс салгаж, чөлөөт бус хүсэл зоригийн тухай ярьж болохгүй юм. Гегелийн философи дахь чөлөөт хүсэл зоригийг ойлгон танин мэдэхийн тулд хүсэл зоригийг танин мэдэх хөгжлийн үйл явцыг авч үзэх ёстой.

Хүсэл зориг нь хөгжлийн гурван үе шатыг дамжин хөгждөг гэж Гегель үзсэн⁴⁶. Үүнд:

1. Төрөлхийн хүсэл зориг. Энэ үе шатанд хүсэл зоригийн чөлөөт байдал нь зөвхөн өөрөө л эрх чөлөөтэй байдаг байна. Энэ бол эрх чөлөөний боломж. Ийм хүсэл зориг хүүхдэд байдаг бөгөөд түүнд эрх чөлөөтэй, ухаалаг хүн болох боломж бий. Гагцхүү хүүхэд энэхүү эрх чөлөөг мэддэггүй, мөн ухамсарладаггүй байна. Ийм хүсэл зориг бол хэлбэр, агуулгын хувьд чөлөөт бус юм.
2. Дур зорго. Дур зорго нь өөртөө л эрх чөлөөтэй байдаг тул жинхэнэ эрх чөлөө биш юм. Энэ бол формаль эрх чөлөө. Дур зоргын үед хүсэл зоригийн чөлөөт байдал нь хэлбэрийн хувьд л байхаас, агуулгын хувьд чөлөөт бус байна. И.Кант дур зоргыг чөлөөт хүсэл зориг хэмээн төсөөлсөн. Харин Гегель дур зорго, чөлөөт хүсэл зоригийг ялгаж, дур зоргод хүсэл зоригийн чөлөөт байдлын агуулга, хэлбэр нь хоорондоо зөрчилддөг гэж үзсэн. Хүн жинхэнэ эрх чөлөө, чөлөөт хүсэл зоригтой байгаа үед дур зоргоор бус, ёс суртахуунаар өөрийгөө удирдаж, үйл ажиллагаа явуулан, хуулинд ухамсартайгаар захирагдаж байдаг байна. Гегель дур зорго, чөлөөт хүсэл зоригийн ялгааг "ураачийн ажлаар жишээлж авч үзсэн. "Хэрвээ зураач төгс бүтээл бүтээсэн бол ямар бүтээл байх ёстой тийм л бүтээлийг бүтээлээ гэсэн үг. Энэ үед зураачийн онцгой, өвөрмөц бие даасан байдал үгүй болно. Энэхүү бүтээлд түүний мөн чанар илрэхгүй. Иймд зураачийн ажил хэдий чинээ бүтэмжгүй байна, түүний бүтээлээс өвөрмөц онцлог, дур зорго илрэх болно"⁴⁷ гэжээ.
3. Чөлөөт хүсэл зориг. Энэ үед хүсэл зоригийн чөлөөт байдал нь өөрөө, өөртөө эрх чөлөөтэй байх бөгөөд агуулга, хэлбэрийн ялгаа байхгүй болно. Энэ бол чөлөөт хүсэл зоригийг танин мэдэх III дахь шат. Хүсэл зориг нь хэлбэр, агуулгын хувьд эрх чөлөөтэй юм. Эндээс л Гегелийн үзлээр хүсэл зориг нь сэтгэхүйн онцгой арга, бодит ахуйд өөрийгөө хувиргасан сэтгэхүй болохыг олж харж болно.

Иймд жинхэнэ чөлөөт хүсэл зориг нь ухаалаг, зохистой хүсэл зориг байна. Өөрөөр хэлбэл, чөлөөт хүсэл зориг бол ухамсарт хүсэл зориг буюу эрх чөлөөний илрэл юм. Харин жинхэнэ эрх чөлөө бол ухамсарласан зайлшгүй байдал. Ёс суртахуунтай хүн өөрийн үйл ажиллагааны агуулгыг ухамсарлах тусмаа хохирол бага учруулдаг байна. Жинхэнэ эрх чөлөө бол зайлшгүй байдлыг ухамсарлан танин мэдэх явдал. Иймд эрх чөлөө нь дур зорго бус. Хүн чөлөөт байдлаа ухамсарлах нь зайлшгүй чухал бөгөөд энэ нь чөлөөт хүсэл зоригийн илрэл аж. Гегелийн үзлээр, оюун ухааныг ухамсартайгаар зорилгоо болгосон чөлөөт байдал л жинхэнэ чөлөөт байдал болдог. Эрх чөлөө нь танигдсан зайлшгүй байдал тул танин мэдэхүйн хэрээр өсөн нэмэгдэж байдаг байна. Иймд хүн орчин тойрны юмс үзэгдэл, байгаль

⁴⁵ Гегель. Философия права. М. 1990. С. 32-33

⁴⁶ Мөн тэнд. С. 37-44

⁴⁷ Мөн тэнд. С. 45

нийгмийг таниж мэдэх тусам эрх чөлөөтэй болж байна гэсэн үг. Хэрвээ жам ёсны эрхийн онолоор хүн төрөлхөөсөө байгалиас заяагдсан эрх, эрх чөлөөгөө зайлшгүй эдлэх ёстой гэж сургадаг бол, Гегель байгалаас заяасан эрх гэж үгүй, харин хүн гадаад ахуйгаа зөв ухаалгаар таниж мэдсэн, оюун ухаан руу тэмүүлэх бие хүн л жинхэнэ эрх, эрх чөлөөгөө олж авна гэж үзсэн.

Ийнхүү Гегель нь эрх чөлөө, зайлшгүй байдлын харилцан хамаарлыг зөв тодорхойлсон бөгөөд Гегелийн боловсруулсан эрх чөлөөний философи нь орчин үеийн эрх чөлөөний сэтгэлгээний нэг гол үндсэн чиг хандлагыг тодорхойлсоор байна.

Гегель “эрх - чөлөөт хүсэл зоригийн бодит ахуй”⁴⁸ гэж тодорхойлжээ. Түүний эрхийн ойлголтыг танин мэдэхийн тулд эрхийг танин мэдэх хөгжлийн процессыг авч үзэх шаардлагатай юм. Гегель эрхийг танин мэдэхүйн хөгжлийн процессыг түүхэн бус, танин мэдэхүйн логик процесс хэмээн үзэж, 3 үе шатанд хуваасан байна. Үүнд:

1. Хийсвэр эрх - чөлөөт хүсэл зоригийн гадаад бодит ахуй. Энэ бол бие хүний хүсэл зоригийн гадаад бие даасан хэлбэр. Иймд хийсвэр эрхийн хүрээнд хүмүүсийн харилцааны объектив тал илэрдэг. Хийсвэр эрхийн үндсэн ойлголт нь бие хүний ойлголт. Гегель хийсвэр эрхийн хүрээнд бие хүний эрх чөлөөний илрэл болох өмчлөх эрх, гэрээ, гэмт хэрэг, ялын асуудлыг авч үзсэн.
2. Зан суртахуун - чөлөөт хүсэл зоригийн дотоод бодит ахуй. Иймд зан суртахуунд хүмүүсийн харилцааны субъектив тал илэрдэг тул хүний үйлдэл, түүний үр дагавар, санаа сэдэл, гэм буруугийн асуудлыг авч үзсэн.
3. Ёс суртахуун - чөлөөт хүсэл зоригийн гадаад, дотоод бодит ахуйн нэгдэл. Иймд ёс суртахууны шатанд хүмүүсийн харилцааны субъектив, объектив тал нэгдмэлээр илэрнэ хэмээн үзэж иргэний нийгэм, төрийн асуудлыг авч үзжээ.

Ёс суртахууны эхний шат нь гэр бүл, хоёр дахь шат нь иргэний нийгэм, гурав дахь шат нь төр болно. Гегель ёс суртахууны ертөнцийг жинхэнэ эрх чөлөөний биелэл хэмээн үзэж, хүн төрд нэгдэж, иргэний эрх, үүргээ ухамсарлан, хуулинд ухамсартайгаар захирагдаж байгаа энэ үед жинхэнэ эрх чөлөө хэрэгжинэ гэжээ.

Нийгэм дэх чөлөөт байдал бол хэсэг бүлэг хүмүүсийн дур зоргоороо авирлахыг даван туулах явдал. Хүмүүсийн хүсэл зоргийн нийгэм дэх хязгаарлал нь гагцхүү эрх зүйгээр зохицуулагдаж, эрх зүйн хэм хэмжээгээр илрэн гарч, эрх зүйн харилцааны хүрээнд л хэрэгжиж байдаг байна.

Дээрхээс үндэслэн эрхийн ойлголт нь Гегелийн философид дараахи утгаар илэрдэг болно⁴⁹. Үүнд:

1. Эрх - эрх чөлөөний санаа. Эрхийг танин мэдэхүйн хөгжлийн эхний шатанд эрх чөлөөний санаа бий болдог. Энэ үед эрх чөлөө, эрхийн ойлголт нь нэг утгатай байна.
2. Эрх - эрх чөлөөний хэлбэр. Эрх чөлөөний санаа нь өөрөө, өөрийгөө мэдэрч ухаарч эхэлсэн явцад эрхийн санаа нь эрх чөлөөнөөсөө салаад тодорхой хэлбэрт орж, өмчлөх эрх, гэрээ, гэмт хэрэг, ял шаардах эрхээр илэрнэ.
3. Эрх - хууль /позитив эрх/. Эрхийн санаа нь энэ үе шатанд хууль тогтоомжийн тодорхой хэлбэрт ордог байна.

Гегель эрх, хуулийг ялгах үзэл санааны явцдаа тэдгээрийг сөргүүлэн тавихгүй байхыг эрмэлзэж, позитив эрхийг эрхийг танин мэдэх тодорхой үе шат хэмээн үзэж байсан боловч, хууль тогтоох явцад эрх нь агуулгаасаа гажих тохиолдол байдгийг хүлээн зөвшөөрч байсан. Энэ үндсэнд хууль нь эрхийн илрэн гарах хэлбэр юм. Иймд эрхийн агуулгаас гажсан хууль

⁴⁸ Гегель. Философия права. М. 1990, С. 53

⁴⁹ Под. Ред. В.С. Нерсисянца. История политических и правовых учений. М. 1988. С.340-341

бол эрх биш⁵⁰ хэмээн үзсэн. Гегелийн хэлсэнчлэн нийгмийн амьдралд хүний эрхийг үгүйсгэж, эрхийн агуулгаас гажсан хуулиуд нилээдгүй гарч байсныг өнгөрсөн түүх гэрчилнэ.

Тухайлбал, хүний эрх чөлөөний илрэн гарах анхдагч хэлбэр болох өмчлөх эрхийг үгүйсгэсэн хуулиудыг социалист чиг баримжаагаар хөгжиж байсан улс орнууд гаргаж байсан. Мөн 1992 оны Монгол Улсын Үндсэн Хуулиар хүний эрхийг баталгаажуулж, 6.3-д: “Бэлчээр, нийтийн эдэлбэрийн ба улсын тусгай хэрэгцээнийхээс бусад газрыг зөвхөн Монгол Улсын иргэнд өмчлүүлж болно” гэж заасан байхад, 2002 оны 6-р сарын 28-ны “МУ-ын иргэнд газар өмчлүүлэх тухай” хуулинд иргэнд бус, гэрбүлд газрыг эзэмшүүлэхээр зааснаар иргэний газар өмчлөх эрхийг зөрчиж, үгүйсгэсэн байна. Иймд эрх, хуулийг ялгаж, хууль эрхийн шинжийг агуулсан эсэхэд хариулт өгөх нь чухал юм. Өөрөөр хэлбэл, эрхийн дагуу хууль болон эрхийн бус хуулийг ялган зааглах шаардлагатай байна.

Ийнхүү эрхийн тухай Гегелийн ойлголт И.Кантынхаас ялгаатай. И. Кантын үзлээр, “эрх бол хүний зайлшгүй дагаж мөрдөх хэм хэмжээний дагуу нэг субъектын дур зорго, нөгөө субъектын дур зорготой зэрэгцэн орших бүх нөхцөл” юм. Энэхүү ойлголтын үндэс нь бие хүний чөлөөт хүсэл зориг буюу дур зорго /И. Кант/ байна. Харин Гегелийн эрхийн ойлголтын үндэс нь тодорхой субъектын хүсэл зориг бус, бүх нийтийн хүсэл зориг байдгаараа ялгаатай болно. Субъектын хүсэл зоригоор дамжин бүх нийтийн хүсэл зориг илрэнэ гэж үзсэн юм. Гегелийн үзэл санааны онцлог нь эрхийн мөн чанар, ойлголт нь нэг субъектын хүсэл зориг, ашиг сонирголоос хамаарахгүй, хамаагүй дээгүүр байна хэмээн үзсэнд оршино. Ийнхүү Гегель эрхийг философийн категорийн агуулга, хэлбэрийн үүднээс авч үзэхдээ индивидуаль аргаар хандсангүй.

Орчин үед эрхийн тухай Гегелийн ойлголт, түүнд хандах онол - арга зүйн асуудлыг үгүйсгэн шүүмжилсэн хандлага ажиглагдахгүй байна. Эрхийн тухай Гегелийн ойлголт, түүнийг танин мэдэх арга зүйн асуудал нь эрх зүйн сэтгэлгээний хүрээнд онол – арга зүйн ач холбогдолтой хэвээр байгаа болно.

Legal conception of German classical philosopher Hegel G.B.

The theoretical and practical approaches to the legal conception of Hegel have still had particular status in the contemporary legal studies (jurisprudence). I have aimed to make the comparative study of the Hegel's legal conception and its theoretical-practical issues, that have been considered as theoretical and practical roots of the contemporary legal conceptions, with Kant's legal philosophy.

Ашигласан ном

1. Гегель. Философия права. М. 1990.
2. А.А. Пионтковский. Учение Гегеля о праве и государстве. М.1993
3. В.С. Нерсисянц. Философия права. М. 1997
4. Под. Ред. В.С. Нерсисянца. История политических и правовых учений. М. 1988.
5. Ю.В. Тихонравов. Основы философии права. М. 1997
6. Отв. ред. В.С. Нерсисянц. История политических и правовых учений XXв. М. 1995
7. Под. ред. О.Г. Данильяна. Философия права. М.

⁵⁰ Ю.В.Тихонравов. Основы философии права. М. 1997. С.455